



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

“Азуре хүлүг аудит” ХХК-д даатгалын байгууллагад  
аудит хийх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 7 дугаар хавсралт “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Азуре хүлүг аудит” ХХК-д даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосугай.
2. Аудитын үйл ажиллагааны стандарт, хууль тогтоомжийн дагуу чанарын хяналтыг байгууллагад хэрэгжүүлж ажиллах, чанарын хяналт шалгалтын үнэлгээг тухай бүр тус Хороонд ирүүлэх, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Азуре хүлүг аудит” ХХК /Г.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН